



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
 ТУШААЛ**

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 2/12

Шивээговь сум

**С.Ононтой байгуулсан хөдөлмөрийн  
 гэрээг цуцлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 99 дүгээр зүйлийн 99.10, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.1, 2.8.1 дэхь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын Хогны машины ачигч Сампилын Онон нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул хөдөлмөрийн гэрээг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс цуцалсугай.

2.С.Ононтой холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д үүрэг болгосугай.

3.С.Ононд ажилласан хугацааны амралтын мөнгийг бодож олгохыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ОТГОНЖАРГАЛ